

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕБ-ЫН ХАН-УУЛ СУРГУУЛИЙН
6 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛ
ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

ХУВИЛБАР “А”

ХУГАЦАА 60 МИНУТ

НИЙТ ОНОО 20

ХУШ

Нэгэн цэцэрлэгт хуш мод ургажээ. Он жил өнгөрөх тусам улам томорч, өндөр гоолиг болсоор байж. Гэвч хуш өөдөө тэмүүлэх тусмаа гайхуулж сайрхах нь ихсэв. Саглагар сайхан бие нь бусад модны дээгүүр ганхаж сүүдрээ тэдэн дээр тусгадаг болов.

Хуш бусдыг өөлөн шоолж, ээлжлэн тайруулж дуусчээ. Түүнийг цэцэрлэгийн бүрэн эрхт эзэн болоход цэцэрлэгийн оронд дан хувхайрсан хожуул үлджээ.

Тэгтэл нэг өдөр ер бусын хүчит салхи шуурав. Сагсуу хуш байдгаараа салхи сөрөн, хүчирхэг үндсээрээ газраас зууран тогтож ядлаа. Салхины замд тээглэх өөр мод байхгүй болохоор салхи ум хумгүй уулгалан дайрчээ.

Адаг сүүлдээ тэсэхээ болиод, булга үсэрч газарт тэрийн ойчжээ.
Эхийг ухаарч уншаад, дараах даалгавруудыг гүйцэтгээрэй.

1. Эхийн гол санааг өөрийн үгээр тодорхойлон бичээрэй. \2 оноо\

.....
.....

2. Тодруулсан өгүүлбэрээс 3 бүрэлдэхүүнт цөм өгүүлбэрийг олоорой \2 оноо\

Сагсуу хуш байдгаараа салхи сөрөн арай ядан тогтлоо.

.....

3. Дараах үгсийн утгыг хам орчноос таамаглан, тайлбарлаж бичээрэй. \2 оноо\

Гоолиг-

Сагсуу-

4. Дараах үгсийг тийн ялгалын нөхцөлөөр хувилган бичээрэй. \2 оноо\

Хуш	Өгөх орших	Заах	Үйлдэх	Хамтрах

5. Дараах дүрэмд тохирсон жишээ үг бичээрэй. \2 оноо\

А. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “Л” дагавар залгахад эгшгээ урдаа авна.....

Б. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “Л” дагавар залгахад эгшгээ ардаа авна

6. Зохиолыг зохиолын агуулгатай нь зөв харгалзуулаарай /5 оноо/

- | | |
|--------------------------|---|
| А. Арсландай мэргэн хаан | 1. Монгол банхар нохойны тухай |
| Б. Алт мөнгө хоёр | 2. Хууль бусаар ан агнаж эх үрийг хагацуулж буй тухай |
| В. Шаргачин | 3. Гурван чонын тухай |
| Г. Зүрх цагаан | 4. Ах дүү 2-ын тухай |
| Д. Хүүхдийн бор | 5. Бор атны тухай |

.....

7. Эхийг уншаад, хөрвүүлэн бичээрэй. \5 оноо\

Нийт үг – 10 \зөв үг бүр -0.5 оноо\

1.

 2.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕБ-ЫН ХАН-УУЛ СУРГУУЛИЙН
6 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛ
ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

ХУВИЛБАР “Б”

ХУГАЦАА 60 МИНУТ

НИЙТ ОНОО 20

Ороонго өвс

Өндөр хашааны цаана ороонго өвс долоогоно модны эх бие, навчийг ороож ургасан байжээ. Гэтэл ороож ургасаар байгаад оройд нь тулаад эргэн тойрноо ажиг байхдаа замын нөгөө талд бас нэг хашаа байхыг үзжээ. Ороонго өвс дуу алдан:

- Тийшээ очвол мөн сайхан аа. Насаараа нэг газар сахиж болохгүй биз дээ. Хажуугийн хашаа үүнээс хавьгүй өндөр юм гэжээ.

Ингээд атаархан өнөөх чинь зүгээр сууж чадахаа больжээ. Нахиалсан мөчрөө улам улам уртасган, хоног өдөр өнгөрөх тусам санасандаа хүрэхэд дөхөж байж. Ашгүй ингээд удтал хүлээсэн мөч ч боллоо. Дахиад нэг зүтгээд үзсэн чинь ороонго айлын хашааны модны мөчрөөс зууран залгалдаж, баттай ороогоод авах нь тэр. Санасандаа хүрч авсандаа ороонго магнай хагартлаа баярлаж, ам бардам байв.

Тэгтэл үдшийн цагаар оройтож явсан нэг хүн замаар гараад ирлээ. Огт санаандгүй тээглэсэн ороонгоны ногоон хэлхээ навчийг тэр хүн тас татаад, хажуугийн шуудуу руу шидэж орхижээ.

Эхийг ухаарч уншаад, дараах даалгавруудыг гүйцэтгээрэй.

1. Эхийн гол санааг өөрийн үгээр тодорхойлон бичээрэй. \2 оноо\

.....
.....

2. Тодруулсан өгүүлбэрээс 3 бүрэлдэхүүнт цөм өгүүлбэрийг олоорой \2 оноо\

Өндөр хашааны цаана ороонго өвс модны эх бие, навчийг ороож ургасан байжээ.....

3. Дараах үгсийн утгыг хам орчноос таамаглан, тайлбарлаж бичээрэй. \2 оноо\

Ажих-

Шуудуу-

4. Дараах үгсийг тийн ялгалын нөхцөлөөр хувилган бичээрэй. \2 оноо\

Навч	Өгөх орших	Заах	Үйлдэх	Хамтрах

5. Дараах дүрэмд тохирсон жишээ үг бичээрэй. \2 оноо\

А. Гийгүүлэгчээр төгссөн үгэнд я,ё,е-г залгахад хатуу болон зөөлний тэмдгийг эгшиг зохицох ёсны дагуу жийрэглэн бичнэ-.....

Б. Эгшгээр төгссөн үгэнд я,ё,е-р эхэлсэн залгаврыг шууд залган бичнэ-.....

6. Зохиолыг зохиолын агуулгатай нь зөв харгалзуулаарай /5 оноо/

А. Шударга шүүгч

1. Хүний хүсэл, үл ханах шунаг сэтгэлийн талаар

Б. Цаасан онгоц

2. Байгаль орчин, модоо хайрлах

В. Шидэт бийр

3. Хүний мөн чанарыг таних

Г. Лакшмын соёрхол

4. Аливаа хэрэг явдлыг шударгаар шүүх тухай

Д. Ас-Синдбад хааны үлгэр

5. Зугаа цэнгэлд дуртай хааны тухай

.....

7. Эхийг уншаад, хөрвүүлэн бичээрэй. \5 оноо\ Нийт үг – 10 \зөв үг бүр -0.5 оноо\

1. Өмнөд хэсэгт үгсийг уншиж, тэдгээрийг хөрвүүлэн бичээрэй.
 2. Өмнөд хэсэгт үгсийг уншиж, тэдгээрийг хөрвүүлэн бичээрэй.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....